

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН – Хуралдааны тойм

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛЫН ХӨТӨЛБӨР ¹ 07 (ТОЙМ)

Хуралдаан 2010 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 10.10 цагт эхэлж, 14.10 цаг хүртэл Засгийн газрын Х1 байрын (П давхрын дугуй зааланд эхний 1 дүгээр асуудлыг өргөтгөсөн байдлаар хийв) 301 тоот өрөөнд болж, нийт 4 цаг 00 минут үргэлжлэв.

1	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Нийслэлийн дүүргүүд, түүний харъяа зарим байгууллагын төрийн албан хаагчийн хэрэгцээ, хангалтын үйл ажиллагааг шалган зааварласан дүнгийн тухай	<p>Нэг. 1.Удирдах ажилтны сонгон шалгаруулалтгүйгээр томилогдсон Сонгинохайрхан, Хан-Уул, Баянзүрх, Сүхбаатар, Багануур, Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга нар, дээр дурдсан 6 дүүргийн болон Баянгол, Чингэлтэй, Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газрын зохион байгуулалтын бүтцийн 55 нэгжийн дарга нар болон шалгалтад хамрагдсан байгууллагын ерөнхий менежерийн үүрэг гүйцэтгэх албан тушаалын сул орон тоон дээр томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын “Хоёр”-ын 10, “Гурав”-ын 14-16, Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 126 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 2.1.7-д заасныг тус тус баримтлан энэ оны 6 сард багтаан сонгон шалгаруулж, томилуулах;</p> <p>2.Баянзүрх дүүргийн 7, Сүхбаатар дүүргийн 10, Баянгол дүүргийн 10, Хан-Уул дүүргийн 4, Налайх дүүргийн 9, Багануур дүүргийн 4 буюу нийт 44 төрийн захиргааны албан тушаалын сул орон тоон дээр журам зөрчин томилогдон ажиллаж буй хүмүүсийг ажлаас нь чөлөөлүүлж, сул орон тоог Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 99 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх журам”-ын 5.1, 6.2-т заасныг баримтлан энэ оны 4 дүгээр сард багтаан нөхүүлэх арга хэмжээг авахыг Нийслэл дэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд тус тус даалгах,</p> <p>Хоёр. Удирдах ажилтны сонгон шалгаруулалтаар томилогдоогүй Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул, Багануур, Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга, дүүргийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний нутгийн захиргааны байгууллагын дарга нарыг албан тушаалаас нь чөлөөлж, сул орон тоог нөхөх захиалгыг Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны</p>

		<p>удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-ын 14-ийн "в"-д заасан чиг үүргийнхээ дагуу 2010 оны 04 дүгээр сарын 01-ний дотор Нийслэл дэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд ирүүлэхийг холбогдох дүүргийн Засаг дарга нарт чиглэл болгох,</p> <p>Гурав. 1.Төрийн захиргааны албан тушаалын сул орон тоон дээр журам зөрчин томилогдон ажиллаж буй хүмүүсийг албан тушаалаас нь чөлөөлж, сул орон тооны захиалгыг Нийслэл дэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд ирүүлж, зохих журмын дагуу нөөцөөс нөхөх,</p> <p>2.Нийслэлийн дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний нутгийн захиргааны зарим байгууллагын төрийн албан хаагчийн хэрэгцээ, хангалтын үйл ажиллагааг шалган зааварласан ажлын хэсгийн илтгэх хуудсанд дурдсан ололтыг бататгах, зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээг шуурхай зохион байгуулж, дүнг 2010 оны 6 сард Нийслэл дэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөр дамжуулан Төрийн албаны зөвлөлд тайлагнахыг Нийслэлийн дүүргүүдийн Засаг даргын Тамгын газрын дарга нарт тус тус даалгах,</p> <p>Дөрөв. Дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар, түүний харьяа зарим байгууллагын төрийн албан хаагчийн хэрэгцээ, хангалтын үйл ажиллагааг шалган зааварлах ажлын явцад илэрсэн зөрчил, дутагдал нь Нийслэл дэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс дүүргүүд, түүний харьяа байгууллагыг төрийн албаны стандартын удирдлагаар бүрэн дүүрэн хангаж ажиллаагүйтэй холбоотой байгаад дүгнэлт хийж, шалган зааварлах ажлын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, цаашид ийм дутагдал гарахгүй байхад чиглэсэн удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг төлөвлөн зохион байгуулж, дүнг Төрийн албаны зөвлөлд 2010 оны 6 сард багтаан танилцуулахыг Нийслэл дэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дарга Ц.Болдсайханд үүрэг болгох,</p> <p>Тав. Энэ удаагийн шалган зааварлах ажилд хамрагдсан Нийслэлийн дүүргүүд, түүний харьяа зарим байгууллагаас бусад Нийслэлийн болон дүүргийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулж буй орон нутгийн агентлагт төрийн албан хаагчийн хэрэгцээ, хангалтыг зохих удирдамжийн дагуу шалган зааварлаж, илэрсэн зөрчлийн мөрөөр авсан арга хэмжээний дүнгийн тухай сонсголоо энэ оны 9 дүгээр сард Төрийн албаны зөвлөлийн хуралдаанд тавьж хэлэлцүүлэхийг Нийслэл дэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дарга Ц.Болдсайханд үүрэг болгох,</p> <p>Зургаа. Нийслэл дэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга нарыг оруулах эсэх болон тус Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргыг орон тооны болгох асуудлыг Салбар зөвлөлтэй хамтарч судлан, саналаа Төрийн албаны зөвлөлийн хуралдаанд 2010 оны 06 дугаар сарын 01-ний дотор танилцуулах, энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Шалган зааварлах</p>
--	--	---

		<p>ажлын хэсгийн ахлагч, Төрийн албаны зөвлөлийн гишүүн Б.Өнөбаатарт даалгасан тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> <p>П. 2008 оны орон нутгийн сонгуулиар Чингэлтэй дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчөөр сонгогдон ажиллаж байгаа Х.Батбилэг нь Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2009 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн 326 дугаар тушаалаар нийслэлийн Онцгой байдлын ерөнхий газрын даргаар, 2008 оны орон нутгийн сонгуулиар Хан-Уул дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчөөр сонгогдон ажиллаж байгаа Ц.Мөнхсүх нь тус дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2008 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн 122 дугаар тушаалаар Засаг даргын Тамгын газрын Үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтсийн даргаар томилогдон өнөөдрийг хүртэл ажиллахдаа Иргэдийн Хурлын төлөөлөгчөөсөө чөлөөлөгдөөгүй байгаа нь Төрийн албаны тухай хуулийн дугаар зүйлийн 15.1.8 дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.6 дахь заалтыг тус тус зөрчсөн байх тул Х.Батбилэг, Ц.Мөнхсүх нарт дээрх зөрчлийг арилгаж, хуульд нийцүүлсэн талаарх баримтыг 2010 оны 4 дүгээр сарын 01-ний дотор Төрийн албаны зөвлөлд ирүүлэхийг Чингэлтэй, Хан-Уул дүүргийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга нарт тус тус даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
2	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалт, уг албан тушаалд томилогдох ажилтны нөөцөд бүртгэж, нэр дэвшүүлэх тухай	<p>1.Ургамалын Бямбасүрэн, Гөлгөөгийн Туул, Гочоогийн Цэндсугар, Зинагийн Цэвээндорж нарыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны төрийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны нөөцөд бүртгэх,</p> <p>2.Дээр дурдсан нөөцөд орсон иргэдээс Ургамалын Бямбасүрэнг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилуулахаар санал, дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболдод санал болгох тухай МУ-ын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
3	Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалт, уг албан тушаалд томилогдох ажилтны нөөцөд бүртгэж, нэр дэвшүүлэх тухай	<p>1.Лхасүрэнгийн Бямбасүрэн, Гэндэнпүрэвийн Төмөрбаатар, Алтангэрэлийн Эрдэнэбаатар нарыг Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах албан тушаалтны нөөцийн жагсаалтад бүртгэх,</p> <p>2.Дээр дурдсан удирдах албан тушаалтны нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн иргэдээс Гэндэнпүрэвийн Төмөрбаатарыг Хөвсгөл аймг Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Хөвсгөл аймгийн Засаг дарга Л.Цэрэнжавт санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
4	Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалт, уг	1.Өлзийхутагийн Баянмөнх, Бавуугийн Түвшинбаяр нарыг Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд

	албан тушаалд томилогдох ажилтны нөөцөд бүртгэж, нэр дэвшүүлэх тухай	томилогдох удирдах албан тушаалтны нөөцийн жагсаалтад бүртгэх, 2.Дээр дурдсан удирдах албан тушаалтны нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн иргэдээс Бавуугийн Түвшинбаярыг Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Өмнөговь аймгийн Засаг дарга Б.Бадраад санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
5	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтанд дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын даргын албан тушаалд Хавхын Цолмонг томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж томилох эрх бүхий албан тушаалтанд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
6	Засгийн газрын тохируулагч агентлаг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын Төрийн захиргаа, удирдлагын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтанд дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай	МУ-ын Засгийн газрын тохируулагч агентлаг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын Төрийн захиргаа, удирдлагын газрын даргын албан тушаалд Зөвөөгийн Энхболдыг томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Засгийн газрын тохируулагч агентлаг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дарга Д.Мандахад санал болгох тухай МУ-ын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
7	УИХ-ын гишүүн асан Ц.Төмөртоогоог төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай	1996-2000 онд Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдон ажиллаж байсан Цэвээндоржийн Төмөртоогоог төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай МУ-ын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
8	Цагдаа, дотоодын цэргийн төрийн тусгай албан тушаалд анх орох иргэдийн нөөцийн жагсаалт батлах тухай	1.2010 оны 02 дугаар сарын 23-25-ны өдөр зохион байгуулсан Төрийн тусгай албан тушаалд анх орох иргэний мэргэшлийн шалгалтад тэнцсэн нэр бүхий 48 иргэнийг Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын төрийн тусгай албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэснийг хавсралтаар батлах, 2.Энэхүү тогтоолын нэгдүгээр зүйлд заасан Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын төрийн тусгай албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэсэн иргэдээс онооны дарааллыг баримтлан өрсөлдсөн албан тушаалд нь санал болгож, томилуулахыг Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дарга Д.Сандаг-Очирт зөвшөөрөх, 3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Төрийн албаны мэргэшлийн шалгалтын төв комиссын дарга Д.Батбаярт даалгасан тухай Монгол Улсын Төрийн

		албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
9	Иргэн Х.Лхагвабаатараас ажилд томилохгүй байгаа тухай гаргасан гомдлын талаарх Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийн тухай	<p>1.Төрийн албаны зөвлөлөөс Ашигт малтмалын газрын Статистик мэдээлэл, судалгааны тасгийн Хайгуулын ажлын нөхөн төлбөрийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд нэр дэвшүүлсэн Х.Лхагвабаатарыг Ашигт малтмалын газрын дарга Д.Батхуяг томилохоос татгалзсан нь хууль зүйн үндэслэлгүй гэж үзсэн, Төрийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.4, 17 дугаар зүйлийн 17.2, 17.3, 17.6, 39 дүгээр зүйлийн 39.6, 40 дүгээр зүйлийн 40.1 дэх заалтуудыг зөрчин Төмөрпүрэвийн Буянбатыг Ашигт малтмалын газрын Статистик мэдээлэл, судалгааны тасгийн Хайгуулын ажлын нөхөн төлбөрийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилсон Ашигт малтмалын газрын даргын 2009 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 17 дугаар тушаалын хавсралтын “Технологи, байгаль орчны тасаг” гэсэн хэсгийн “18.Хайгуулын ажлын нөхөн төлбөрийн асуудал хариуцсан мэргэжилтэн Төмөрпүрэвийн Буянбат” гэсэн хэсэг тус тус хууль зүйн үндэслэлгүй гэж үзсэн Төрийн албаны зөвлөлийн Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг зүйтэй гэж үзэх,</p> <p>2.Ашигт малтмалын газрын даргын 2009 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 17 дугаар тушаалын хавсралтын “Технологи, байгаль орчны тасаг” гэсэн хэсгийн “18.Хайгуулын ажлын нөхөн төлбөрийн асуудал хариуцсан мэргэжилтэн Төмөрпүрэвийн Буянбат” гэсэн хэсгийг хүчингүй болгох,</p> <p>3.Ашигт малтмалын газрын Статистик мэдээлэл, судалгааны тасгийн Хайгуулын ажлын нөхөн төлбөрийн асуудал хариуцсан мэргэжилтэн Төмөрпүрэвийн Буянбатыг ажлаас нь чөлөөлж, тус албан тушаалд Х.Лхагвабаатарыг 2010 оны 3 дугаар сарын 29-ний дотор томилж, энэхүү тогтоолын биелэлтийг хангасан тухай Төрийн албаны зөвлөлд мэдэгдэхийг Ашигт малтмалын газрын дарга Д.Батхуягт үүрэг болгох,</p> <p>4.Ашигт малтмалын газрын даргын 2009 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 17 дугаар тушаалын улмаас төрд учирсан хохирлыг тооцож, шүүхэд нэхэмжлэл гарган шийдвэрлүүлж, биелэлтэд нь хяналт тавихыг Төрийн албаны зөвлөлийн Ажлын алба (Ц.Самбаллхүндэв)-нд даалгасан тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
10	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын газрын гадаад харилцааны тасгийн даргаар ажиллаж байсан Д.Чинбатын гаргасан гомдлын талаарх Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийн тухай	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын газрын Гадаад харилцааны тасгийн даргаар ажиллаж байсан Д.Чинбатын гаргасан гомдлын талаарх асуудалд нягталж үзэх зүйл байх тул дараагийн хуралдаанаар хэлэлцэж, шийдвэр-

		лэхээр хойшлуулав.
11	Төв аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай	Төв аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэх болон тус салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн даргын асуудлыг бусад Салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, тэдгээрийн Салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн даргын асуудлыг давхар шийдээд явъя гэж хойшлуулав.
12	Бусад асуудал: Засгийн газрын тохируулагч агентлаг Мэдээлэл, шуудан, харилцаа, холбоо, технологийн газрын дэд даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтанд дүгнэлт гарган, нэр дэвшүүлэх тухай	Засгийн газрын тохируулагч агентлаг Мэдээлэл, шуудан, харилцаа, холбоо, технологийн газрын дэд даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтанд дүгнэлт гарган, нэр дэвшүүлэх тухай асуудлыг уг ажлын байрыг чөлөөлж маргаангүй болгосон нөхцөлд шийдэж өгөх нь зүйтэй гэж үзэв.
